



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 8/178

Чингис хот

**Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг бусдад
шилжүүлэх тухай**

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6, Иргэдээс төрийн багууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу иргэн А.Жаргалсайханы эзэмшлийн 3 дугаар баг, Тээвэрчид-А 44а тоот хаягт байрлах 2311039180 нэгж талбарын дугаартай 1108м2 талбайтай худалдаа, нийтийн үйлчилгээний газрын зориулалттай газрыг холбогдох гэрээ бичиг баримтыг үндэслэн “Сэцэн ханы ордон” ХХК-д газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэдэд газар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, гэрээ байгуулан биелэлтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Ж.Эрхэмбаяр)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн А/39 тоот захирамжийн (А.Жаргалсайхан)-д холбогдох заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР